

Н. Дашзэвэг

«Равжүн» буюу жаран эхэлсээр XVII дахь жаран болоод байна. Равжүн гэдэг төвдөөр (сайтар болсон) гэсэн үг юм. Бас Равжүнг (Лор-ган-жүдэг) ч гэж нэрлэдэг. Энэ бол (60 настай өвгөн жил) гэсэн утгатай үг. Манайхан төвдийн Равжүнг жаран гэж нэрлэж иржээ. Жаран жил тус бүрийн үр дагаврын тухай номлолыг анх Энэтхэгийн эрдэмтэн зурхайч Данранпүрэв буюу Гадсан-раши гэгч номложээ. Энэ номлосон (Лор-ган-жүдэгийн барайшад)» гэдэг цаг тооны бичигт дурьдахдаа: Анхдугаар (Равжүн-сайтар болсон) хэмээх улаагчин гал эм туулай жил нь хур бороо элбэг, үр тариа үлэмжхэн, зуд турхангүй хүмүүн мал өвчин зовлонгүй, олон даяар амар жаргалтай жил гарсан гэжээ. Манай гариг дээр амьдарч байгаа ихэнх хүмүүс нэг бүтэн буюу хагас жаран наслах нь голцуу юм. Харин 2-3 жаран наслах хүн тун ховор, 4-5 бүтэн жаран наслах хүн өдрийн од мэт, хүн эх орондоо амьдарч хөдөлмөрлөснөөр 60 нас хүрээд гавьяаны цалинд ордог нь үндсэндээ нэг бүрэн жаран болоод байгаа учир 60 настай өвгөд, эмгэд, нийгмийнхээ амьдралд баялаг түүхийг туулж хал үзсэн хашир болсон хүмүүс байдаг.

Эртний Энэтхэг. Төвд, Нанхиадын соёл, нийгэм улс төрийн түүх шастир, анагаах ухаан, одон орны гэх ном шастирт үзвэл Равжүн гэдэг он тооллыг их бичсэн байдаг. Ийм учир Равжүнгийн нэрийг ялган мэдэх нь тун хэрэгтэй бөгөөд ялангуяа он тоолол ба түүх намтар сонирхогчдод он жилийг өнгө махбодиор нь олоход маш их чухал юм.

Энд ганцхан жишээг бичвэл «Эртний анагаах ухааны дөрвөн үндэсний нэмэлт судар. Төвдийн их оточ Дэсэрд Санжаажамцын бичсэн (Лхантав-нэмэлт) хэмээх эмийн судрыг (төрлөхүйтний эзэн) хэмээх төмөр хонин жил өөрийн 39 настайдаа бичив гэжээ.

Энэ дурьдсан жил бол 12-р Равжүнгийн доторхи 5-р (төрлөхүйтний эзэн) гэдэг улаагчин төмөр хонин жил буюу 1691 онд тохирч байна. Нөгөө талаар оточ Дэсэрт-Санжаажамц бол 1653 онд төрөөд 1705 онд 55 насандаа бусдад хорлогдон нас барсан тул түүний 39 насны улаагчин төмөр хонин жил тохирч байна. Тэгвэл энэ ном бичигдээд 300 жил болоод байгаа ном юм. Ийм учир бид Равжүн гэдэг тооллыг сайн мэдсэнээр түүхийн ном шастир, хаад, ноёд, хот балгас, чухам аль Равжүнгийн хэддүгээр, ямар махбодитой жилд буй болсныг яг үнэн зөв тодорхойлж чадах ач холбогдолтой юм. Ингээд Равжүнгийн нэр, жил, махбодь зэргийг хүснэгтээр үзүүлбэл:

№ Төвд нэр	Монгол нэр	Махбодь ба өнгө нь	Эхэлсэн нийтийн он тоолол
1. Равжүн	Сайтар болсон хэмээх	Улаагчин гал туулай	1027
2. Намжүн	Тийм болсон хэмээх	Шар шороон луу	1028
3. Гарбуу	Цагаан хэмээх	Шарагчин шороон могой	1029

0 А	1	2	3
4. Рав-нан	Маш согтонги хэмээх	Цагаан төмөр морь	1030
5. Жы-даг	Төрөлхтний эзэн хэмээх	Цагаагчин төмөр хонь	1031
6. Ангара	Ангар хэмээх	Хар усан мич	1032
7. Балдон	Цогт нүүр хэмээх	Харагчин усан тахиа	1033
8. Ой-буу	Бодис хэмээх	Хөх модон нохой	1034
9. На-цод-дан	Насан төгөлдөр хэмээх	Хөхөгчин модон гахай	1035
10. Зэн-жид	Барагч хэмээх	Улаан гал хулгана	1036
11. Ван-чуг	эрхэт хэмээх	Улаагчин гал үхэр	1037
12. Бүрү-ман	Олон үрт хэмээх	Шар шороон бар	1038
13. Нцой-дон	Төгс согтонги	Шарагчин шороон туулай	1039
14. Нам-нон	Баатар хэмээх	Цагаан төмөр луу	1040
15. Чуг-чог	Сүргийн манлай хэмээх	Цагаагчин төмөр могой	1041
16. Нацаг	Элдэв зүйл хэмээх	Хар усан морь	1042
17. Ням	Наран хэмээх	Харагчин усан хонь	1043
18. Нян-дол-жид	Наран гэтэлгэж үйлдэгч хэмээх	Хөх модон мич	1044
19. Сажон	Газар тэтгэгч	Хөхөгчин модон тахиа	1045
20. Ми-сад	Үл барагдагч	Улаан гал нохой	1046
21. Там-жид-дүл	Хамгийг номхотгох	Улаагчин гал гахай	1047
22. Гүн-зэн	Бүхнийг баригч хэмээх	Шар шороон хулгана	1048
23. Гал-ба	Алжаас хэмээх	Шарагчин шороон үхэр	1049
24. Нам-жүр	Тийн урвагч хэмээх	Цагаагчин төмөр бар	1050
25. Бом-бо	Илтгэн хэмээх	Цагаагчин төмөр туулай	1051
26. Гава	Бэрх	Хар усан луу	1052
27. Нам-жил	Тийн ялсан	Харагчин усан могой	1053
28. Жалба	Хаан хэмээх	Хөх модон морь	1054
29. Ной-жид	Нойрсуулагч	Хөхөгчин модон хонь	1055
30. Лоо-ан	Муу нүүрт хэмээх	Гал улаан мич	1056
31. Сэр-чан	Алтан унжлага хэмээх	Улаагчин гал тахиа	1057
32. Нам-чан	Тийн унжсан хэмээх	Шар шороон нохой	1058
33. Жүр-жид	Хөрвөгч	Шарагчин шороон гахай	1059
34. Гүн-дон	Бүхэн төгөлдөр хэмээх	Цагаан төмөр хулгана	1060
35. Пар-ва	Цөөвөр хэмээх	Цагаагчин төмөр үхэр	1061
36. Ги-жид	Буян үйлдэгч хэмээх	Хар усан бар	1062
37. Зээ-жид	Үзэсгэлэнт үйлдэгч хэмээх	Харагчин усан туулай	1063
38. То-му	Хилэнт эх хэмээх	Хөх модон луу	1064
39. Нацаг-ева	Элдэв эрдэнэт	Хөх модон могой	1065
40. Сэл-нан	Сүрээр дарагч хэмээх	Улаан гал морь	1066
41. Би-ру-бү	Сармагчин хэмээх	Улаагчин гал хонь	1067
42. Пүрэв	Гадас хэмээх	Шар шороон мич	1068
43. Ши-ва	Амарлингуй хэмээх	Шарагчин шороон тахиа	1069
44. Түмэн	Нийтийн хэмээх	Цагаан төмөр нохой	1070

0 А	1	2	3
45. Гал-жид	Алжаа үйлдэгч хэмээх	Цагаагчин төмөр гахай	1071
46. Ёонзон	Огоот баригч хэмээх	Хар усан хулгана	1072
47. Баг-мид	Сэргэмжгүй хэмээх	Харагчин усан үхэр	1073
48. Гун-га	Бүхэн баясгалант хэмээх	Хөх модон бар	1074
49. Сэрэн-бүү	Хорхой хэмээх	Хөхөгчин модон туулай	1075
50. Ми	Гал хэмээх	Гал улаан луу	1076
51. Мар-сэр-жан	Улбар шар хэмээх	Улаагчин гал могой	1077
52. Дүй-жи- понио	Цагийн элч хэмээх	Шар шороон морь	1078
53. Дондов	Тусыг бүтээгч хэмээх	Шарагчин шороон хонь	1079
54. Даваг-бу	Догшин хэмээх	Улаан төмөр мич	1080
55. Лоо-ан	Муу оюут хэмээх	Цагаагчин төмөр тахиа	1081
56. А-чин	Их хэнгэрэг хэмээх	Хар усан нохой	1082
57. Таг-жүг	Цусаар бөөлжигч хэмээх	Харагчин усан гахай	1083
58. Мягмар	Улаан нүдэт хэмээх	Хөх модон хулгана	1084
59. Той-бу	Хэлэмт хэмээх	Хөхөгчин модон үхэр	1085
60. Сад-ва	Барагдагч хэмээх	Улаагчин бар	1086

Тайлбар: Жаран эхлэх нь ямагт дээрээ гурван оронтой ямагт 7-гоор төгсөж байдгийг санаарай.

Жишээ нь: 1-р жаран маань 1027 буюу улаагчин гал туулай жил эхэлсэн байх ба одоо XVII жаран мөн дахин эргэх улаагчин гал туулай жил болох 1987 онд эхэлж одоо XVII жарны дөрөвдүгээр жил (Жы-даг) буюу төрөлхүйтний эзэн хэмээн цагаагчин эм хонин жил болоод байна. Энэ хонин жилийг «Сайтар номлосон бүхний хураангуй» хэмээх зурхайн ном сударт үр дагаврыг нь номлохдоо: энэ жил хүмүүн малын өвчин арилж, нааш цааш тэмцэлгүй зохилдож, үнээ сарлаг тэргүүтний сүү сааль арвижин дэлгэрнэ. Түүнээс гадна Төвдийн XIV Далай лам анх Монголд хонин жил заларсан. Энэ жил бас хонин жилийн намар дахин заларч ирэх гэж байгаа нь их өлзий бэлэгтэй сайн сайхан үйл дэлгэрэх учиртай гэж хөдөлмөрчид, малчид ерөөж байна.